



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Цагаан шонхор" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 7 нэрийн, нийт 2,740,900.00 (хоёр сая долоон зуун дөчин мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ, 2,666,420.80 (хоёр сая зургаан зуун жаран зургаан мянга дөрвөн зуун хорин төгрөг наян мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, "Цагаан шонхор" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Мөнх-Оргил нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001633

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 2-р дугаар сарын 2-ны өдрийн
10% дугаар тогтоолын хавсралт

"ЦАГААН ШОНХОР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон, бүртгэсэн огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1.Машин тоног төхөөрөмж								
1	Хэрээсний машин /5 утастай 1/	2016/01/28	825,000.00	ш	1	825,000.00	825,000.00	-
2	Размер хэвлэгч машин	2016/03/03	481,900.00	ш	1	481,900.00	481,900.00	-
3	Эсгүүрийн жижиг машин	2015/10/22	110,000.00	ш	1	110,000.00	110,000.00	-
4	Эсгүүрийн машин	2012/08/01	494,000.00	ш	1	494,000.00	494,000.00	-
5	Эсгүүрийн машин жижиг	2012/04/03	280,000.00	ш	1	280,000.00	280,000.00	-
	Дүн					2,190,900.00	2,190,900.00	-
2.Биет бус хөрөнгө								
1	Бараа материалын сүлжээ програм	2016/04/07	275,000.00	ш	1	275,000.00	237,760.40	37,239.60
2	Кассын сүлжээ програм	2016/04/07	275,000.00	ш	1	275,000.00	237,760.40	37,239.60
	Дүн					550,000.00	475,520.80	74,479.20
	Нийт дүн					2,740,900.00 (хоёр сая долоон зуун дөчин мянга есөн зуун)	2,666,420.80 (хоёр сая зургаан зуун жаран зургаан мянга дөрвөн зуун хорин төгрөг наян мөнгө)	74,479.20 (далан дөрвөн мянга дөрвөн зуун далан есөн төгрөг хорин мөнгө)